

ОРОС-ЧИНГИЙН ХАРИЛЦААН ДАХЬ 1785 ОНЫ “УЛААЛЗАЙН ХЭРЭГ”

Цонгоол Б.Нацагдорж

Товч агуулга: Орос-Чингийн хооронд удаан үргэлжилсэн дайныг эцэс болгож 1689 онд Нэвчүүгийн гэрээг тогтоосноор Амар мөрний дагуух Орос Чингийн хилийн шугам тодорхой болжээ. Энэ үеийг хүртэл бие даасан тусгаар байдлаа хадгалсаар ирсэн Халх нь халх-ойрадын дайны үр дүнд Чингийн төрд дагаар орсноор Чин улс нь Тагнын нуруу хүртэл оросын эзэмшилтэй шүүд хил залгах болсон тул энэ хил хязгаарыг тогтоож 1727 онд Буурын гэрээг тогтоосон билээ. Энэ гэрээний дагуу Орос-Чин хоёр Хиагт болон Цурхайтын амаар худалдаа хийх болсон бөгөөд хожим Чин улс 1755-1758 онд Зүүнгарыг эзлэн авах явцад Орост ойн гарсан ойрадуудыг буцааж авах явдлаар хоёр улсын хооронд ширүүн маргаан үүсч улмаар Хиагтын хилийн худалдаа 1762-1768 оны хооронд зогсчээ. 1768 онд Хиагтын гэрээнд нэмэлт оруулснаар Орос-Чингийн харилцаа хэвийн байдалд эргэн орж худалдааг сэргээсэн байна. Гэвч 1785 онд Чингийн хилийн дотор нэгэн хэрэг дэгдсэн нь Орос-Чингийн хоорондох харилцааг тасалдуулж Хиагтын худалдааг хаахад хүргэсэн бөгөөд хоёр улсын хооронд байгуулсан гэрээг хэрхэн ойлгох тухай харилцан ойлголцолд дөнгөж 8 жилийн дараа хүрсэн юм. Тус өгүүлэлд бид энэ тухай ярихыг зорьлоо.

Түлхүүр үг: Улаалзайн хэрэг, Орос-Чингийн харилцаа, гэрээ, худалдаа

1.Хятад худалдаачныг тоносон хэрэг ба түүнийг шийтгэсэн тухай

Монгол улсын үндэсний төв архивын Хүрээ сайдын архивт хадгалагдаж буй баримтад түшиглэн өгүүлбэл, Тэнгэрийн тэтгэсний 47-р онд (1782) худалдааны иргэн Жин Мин хэмээх Хайсандай гэгч Түшээт ханы чин ван Цэвэгдоржийн хошуунд худалдаалах тэмдэгт бичгээ авч Хүрээнээс гараад, худалдаалан явсаар урианхайн нутаг Цэцэн адаг хэмээх газар “цасанд саатан” сууж байх үес, түүнийг Тэнгэрийн тэтгэсний 48-р он (1783) 4 сарын шинийн 3-ны шөнө хэсэг дээрэмчин довтлон ирж тоножээ.

“tehi jakūci aniya duin biyai ice ilan i doburi duin sunja hūlha jifi etuhuśeme ini boode dosifi ini beye, jai ini hoki irgen tiyan jen bing be

gemu tantame huthufi booi tule kemuni utu hülha bisire be sabuhakū, ini turihe sejen be tuwakiyara juwe monggo hūsun be aššaburakū obume gelebufi ini booi dolo bisire suje, boso, tonggo, cai, dembegu i jergi jaka hacin be gemu tabcilafi sejen de bisire emu uhun i suku be inu gamaha”¹

“дөчин наймдугаар оны дөрвөн сарын шинийн гурваны шөнө дөрөв таван хулгай ирж хүчирхэн түүний гэрт орж түүний бие нөхөр иргэн Тян Жэн Бинг цөм жанчин хүлэж гэрийн гадна басхүү хэдэн хулгай бүхийг мэдсэнгүй, түүний хөлсөлсөн ачаа харгалзах хоёр монгол хүчнийг хөдөлгөхгүй болгон айлгаж түүний гэрийн дотор бүхий торго, бөс, утас, цай, тамхины зэрэг эд зүйлийг цөм довтлон ачаанд бүхий нэг боодол арьсыг мөн авав.”

Дээрэмчдийг явсны сүүлээр Жин Мин хүлгээ алдруулан тоногдсон эд зүйлээ бүртгэн харьяат урианхайн бүгдийн даргад гомдол мэдүүлсэнд, тэд огт ойшоохгүй тул Хүрээнд ирж гомдол мэдүүлжээ. Хүрээ сайдаас Улиастайн жанжин Күйлинд бичиг явуулж энэ хэргийг илрүүлэхийг даалгасан боловч хулгайч нар олдохгүй нилээд удсан байна. Тагна урианхайн бүгд захирах туслагч тайж Дэлэгдаш нар хүн томилон сурвалжлуулсны дүнд мөн оны 11-р сард, Дамбай хэмээгч урианхай хүн архи уун согтоод, *“түүний бие Жамцын цуг орос хариад”* нарыг нөхөрлөж иргэн Хайсандайн эд зүйлийг довтлосон”² хэмээн өөрийн сумны Гомбод ярьсныг тэр нь дээш мэдүүлснээр энэ дээрмийн хэрэг илэрчээ. Күйлин тэр даруй Дамбай, Жамц нар болон мөн хэрэгт холбогдсон Буд, Зөөлөн, Хажилан, Соном, Ширудай, Бажилаг нарыг бариулж Хүрээнд хүргүүлсэн нь бүгд урианхайн бүгдийн дарга Дамиранжавын занги Лувсангийн сумны харьяат хүмүүс бөгөөд Буд, Бажилаг хоёр нь Жамцын хүүхдүүд, Зөөлөн нь Хажилангийн хүү, бүгд гэр харуулын дотор Булган тал гэх газар нутаглах урианхай нар байжээ. Жил бүр тэмдэгт бичиг аван Чингийн эзэн хаанд алба өргөх арьс олж авахын тулд харуулыг гарч гөрөөчлөн явдаг тул оросын харьяат нартай тааралдаж танил тал болсон улсууд агаад буриад нараас буу зэвсгийн зүйл арилжин авах зэргээр тэдэнтэй нилээд чөлөөтэй харилцаж явсан байдал үзэгдэж байна. Дамбай нарын 5 хүн 1783 оны 2 сард Уйлган харуулаар хил гарч гөрөөчлөн явахдаа Улалзай нарын 8 хариад хүнтэй таарчээ. Улалзай нар *“танай энд баян маймай хүн бий юу? Байх аваас бид бас*

¹ МУУТА, М-1, Д-1, хн-3094, х.16

² Энд тэмдэглэхэд энэ нэгэн хэрэгт холбогдсон оросын харьяат нарыг хариад хэмээсэн нь буриад нарыг нэрлэх дархад урианхай нарын нэр бололтой бөгөөд Монгол улсын Хөвсгөл, Завхан аймгуудад хариад овогтон байдаг нь өөрсдийн гарлыг буриад нартай холбож домоглодог байна. БНМАУ-ын Угсаатны зүй. 1-р боть. Улаанбаатар. 1989, х.38

³ МУУТА, М-1, Д-1, хн-3094, х.18

сэмээр харуулыг орж эрэн одсугай” хэмээн өдөж асуусанд тэдний нэг Соном эд хулгай хийх гэж байна хэмээн хэлсэнд тэр 8 хариад нар даруй мордон зайлж яваад, Дамбай, Соном хоёроос салан харьж явсан Буд, Зөөлөн нарыг угтан ирж Будын эцэг Жамцад буу арилжин явсан тул таних учраас түүнийг газар болзон дуудуулаад бүгд нийлэн ойр орчимд худалдааны иргэнийг эрэн явж, Эг гол хүрсэн ч ер таарсангүй тул тэд хойш буцжээ⁴. Түүний хойно 4 сарын 3-нд Улалзай нар бас дахин ирэхэд Дамбай, Жамц тэргүүтэй улсууд очиж буу болон хутга арьс, үсээр арилжин авсны дараагаар Улалзай тэдний зүг хандаж “тэр урьд удаа хулгай хийж чадсангүй...Одоо бид зургаан хүн ирж манай дөрвөн хүн уулын бургасанд нуун хүлээж байна. Танай энд маймааны хүн байвал энэ шөнө хулгайлан одсугай” гэхчлэн хэлэлцээд Жамц даруй мордон Цэцэн адаг хэмээх газар суусан Хайсандайн байдлыг мэдэж ирээд тэр шөнөдөө Улалзай нарын 6 хүнтэй нийлэн одож түүнийг довтлон дээрэмджээ. Жамц дээрэмдсэн зүйлээс юм авсангүй бүх зүйлийг Улалзай нарт өгөөд сүүлд нэг сайн буу эсвэл хэдэн сайн морь авахаар тохироод Дамбай, Хажилан нар энэ хэргийг мэдсэн тул Дамбайд нэг буу болзсон газарт үлдээн яв гэж захиад энэ тухайгаа Дамбайд хэлж, хариад нарын Төмстэй уулын гууд орхисон бууг Дамбайд авч өгчээ. Түүний сүүлээр 6 сарын 20-доор Жамц Дамбайг урьд тохиролцсон ёсоор буу морио авхуулахаар Улалзайн хамт явсан Эрбэнэйд илгээсэнд Дамбай, Уйлган харуулаар оросын хилийг гарч Цанага⁵ хэмээх газар хүрээд Эрбэнэйг сурвалжлан очсонд тэр,

“mini tehe boo meni karun de hanci suwe mini boode geneci
ojorakū, suwe jidere de meni karun i urse gemu sabuha tere bi te
bure de mangga, suwe marifi jamsu de alafi, jakūn biyai juwan
deri suweni karun i tule ubasi birai bade bi jai buki”

“миний суусан гэр манай харуулд ойр. Та миний гэрт одвоос
болохгүй. Таны ирэхийг манай харуулын ард цөм мэдэв. Би
эдүгээ өгөхөд бэрх. Та одож Жамцад хэл. Найман сарын
араадаар танай харуулын гадна Убаши голын газарт би
өгье”

гээд юм өгсөнгүй тул буцаж ирсэн бөгөөд түүний хойно Жамц, Дамбай нар гурван удаа харуул гарч болзсон газар Эрбэнэйг хүлээсэн боловч тэр ирсэнгүй өөрийн дүү Хашига нарыг зарж, элдэв албанд зарагдан яваа тул ирж чадахгүй байна хэмээн буу морь зэргийг өгсөнгүй ажээ⁶. Тэгээд, удалгүй

⁴ МУУТА, М-1, Д-1, хн-3094, х.18

⁵ Эдүгээ ОХУ-ын Буриад улсын Захаамин (Закамна) аймгийн Санага тосгон.

⁶ МУУТА, М-1, Д-1, хн-3094, х.18

Хайсандай нарыг дээрэмдсэн улсыг эрж эхэлсэн тул дахин харуул гарч чадсангүй байсаар баригджээ.

Энэ хэргийг байцаах явцад харуулд сууж хил зөрчигчдийг баривчлах үүрэгтэй харуулын дарга цэргүүд өөрсдөө харуулаар орж гаран оросын харьяат нартай харилцаж буу мэтийг арилжин авч, урианхай, хариад нар нааш цааш харуулаар гаран явч байхыг үзээгүй дүр үзүүлэн дээш мэдүүлдэггүй байсан явдал илэрсэн бөгөөд Хүрээний сайд хожим оросын захын хэргийг шийтгэгчидтэй энэ хэргийг хэлэлцэхэд энэ мэт байдлыг бодитоор үзүүлэх баримттай болохын тулд тэргүүн зэрэг тайж Цэвээнжавыг хэрэг гарсан харуулд илгээжээ. Цэвээнжав нар хэрэг гарсан Уйлган харуулд хүрч очоод 12 хүнийг авч гөрөөчлөх байдлаар харуул гарган илгээсэн бөгөөд 1784 оны эхээр цагаан сарын үеэр нохой дагуулан гөрөөчилж явсан ба урианхай нар тааралдвал арилжин солилцохоор бараа авч явсан Боргил, Содов хэмээх хоёр хариад хүнийг барьж олжээ⁷. Ингээд тэдгээр баригдсан урианхай нар болон хоёр хариад нарыг Хүрээнд илгээж хориулаад, Хүрээний сайдын газраас Эрхүүгийн губернаторт бичиг илгээж тэдний харьяат хариад Улалзай нарыг барьж захын газар Хиагтад авчран Жамц нартай ам нийлүүлэн байцааж хэрэг үнэн мөн болох нь нотлогдвол Жамц, Буд, Зөөлөн нарыг захын газар цаазалж толгойг харьяат нутагт илгээх ба хоёр хариадыг зуун ташуур жанчиж орос нарт буцаан өгч чандлан захируулахаар Гадаад Монголын Төрийг засах явдлын яамнаас шийдвэрлэж хаанаас зөвшөөрөл олсон аж. Ингээд 1784 оны 8 сард Хиагтын газар заргач Юнлин нар оросын майор Налабородинтай хэрэг шүүсэнд Улалзай нар Жамцтай нийлэн харуул нэвтрэн ирж иргэн Хайсандай хэмээх Жин Минг довтолж дээрэмдсэн нь ил болж, Хиагтын гэрээгээр тогтоосон ёсоор алдсан буюу дээрэмдсэн зүйлийг арав дахин нугалж ял төлбөр гаргах ёсоор Жин Мингийн дээрэмдүүлсэн 300 гаруй лан барааны ор ял болгон 3597 лан мөнгө Чингийн талд тушаахаар болсон боловч Улалзай нарыг захын газар цаазлах талаар маргаан гарчээ. Учир нь Орост Елизавета Петровнагийн үеэс эхлэн дээрмийн хэргийн төлөө цаазаар авах ял оноохгүй, ташуураар жанчиж хүнд ажилд хол газар цөлөх болсон байжээ⁸. Ийнхүү ташуураар жанчихад хэрэгтэн ихэвчлэн үхдэг тул оросууд Улалзай нарыг жанчиж шийтгэе гэсэн бөгөөд Чингийн талаас 1779 онд оросын арван нэгэн морь хулгайлсан баргын Гемпил, Халзанхүү нарыг харуул дээр авчран оросуудад үзүүлэн цаазаар авсан хэргийг тэмдэг болгон оросын зүгээр ташуурдан

⁷ МУУТА, М-1, Д-1, хн-3094, х.18

⁸ Очерк истории смертной казни в России. Речь, читанная на годичном акте Императорского Казанского университета ордин. проф. Н. П. Загоскиным. // Известия и ученые записки Казанского Университета — 1892 г. - №1

өнгөрөөхийг эсэргүүцжээ⁹. Тэгэхэд нь оросын майор Налабородин хэрэг хэлэлцэхгүй хэмээсэнд, Хиагтын заргач Юнлин өөрийн худалдаачдад тушааж оросын Хиагтад одож худалдаа хийлгэхийг зогсоох байдал үзүүлсэнд Налабородин эрхгүй зөвшөөрч ор ялын мөнгийг шилжүүлсэн боловч Улалзай нарыг шийтгэх талаар тохирч чадсангүй. Хүрээнээс Эрхүүгийн губернаторт бичиг явуулж Налабородиныг хэрэг шийтгэж чадахгүй байна хэмээсэн бөгөөд худалдааг зогсоосон тухай дараах мэт үзэж байв.

*"...иймийн тул манай газраас захын этгээдийн хэргийг тодорхойлоогүй болвоос худалдааг түр зогсоох хууль ёсоор худалдааг зогсоож учрыг гаргаж чамд ухуулан явуулав. Энэ чухам Хиагтын худалдаа танай Орос хялбараар гуйж олсон нь бус, нэгэн мунхаг хамуурсан майорын учираа даруй худалдааг татаж түвдэхгүй, губернатор чиний газраас яаж хариу хүргэж ирснийг үзэж жич хожим шийтгэе хэмээх санаа"*¹⁰

Губернатороос энэ хэргийг Сенатад мэдүүлсэн ба хариу бичиг хүрж иртэл түр хүлээхийг хүссэн хариу өгсөн бөгөөд хэрэгтнүүдийг авчран Хүрээнд хориулжээ. Харин энэ хооронд энэ хэрэгт холбогдсон улсуудыг шийтгэсэн бөгөөд Уйлган харуулын занги Санжийг цаазаар авж, харуулын тавтыг захирах залан Доржийг тушаалаас огцруулж гурван есөөр торгоод уул хошуунд нь явуулж албанд зүтгүүлэн явуулж, дээрэмд холбогдсон урианхай нарыг захирах занги Лувсанг огцруулан бүгдийн дарга Дамиранжавын 3 жилийн цалинг хасч хөрөнгөнөөс нь иргэн Жин Мингийн хохирол 300 гаруй лан мөнгийг гаргуулан төлүүлээд, Хүрээ сайд Юндэндорж, Лэбүү нарын нэг жилийн цалинг хасч шийтгэсэн бөгөөд бас Улиастайн жанжин Күйлинг урианхайг бүгд захиран шийтгэх хүн тул шийтгэхгүй болохгүй хэмээж мөн нэг жилийн цалинг нь хасч шийтгэжээ¹¹. ТТ 50(1785) оны хаврын тэргүүн сарын 14-нд Оросын талаас хэрэгт холбогдсон хулгайч нараас Буржаг хэмээгч өвчнөөр үхэв хэмээсэнд Юнлин нар хүн томилж ясыг нь үзүүлээд үлдсэн 4 хүнийг мөн тогтсон гэрээ ёсоор цаазаар авахыг шаардсан боловч маргааш нь буюу 1785 оны 2 сарын 16-нд Оросын Хүдэрийн шивээний комендант Налабородин Хиагтын заргач Юнлинд бичиг явуулж Улалзай нарыг жанчин шийтгэж энэ нэгэн хэргийг дуусган шийтгэнэ хэмээн хэлүүлжээ. Юнлин нар хүн зарж энэ хэргийг ийнхүү шууд шийтгэж болохгүй хэмээсэн боловч Налабородин Улалзай нарын

⁹ М-1, Д-1, хн-3094, л.5

¹⁰ МУУТА, М-1, Д-1, хн-3106, х.10

¹¹ М-1, Д-1, хн-3094, х.55; М-1, Д-1, хн-380, х.31-34

хулгайч нарыг ташуураар жанчиж шийтгээд цөлж явуулжээ. Чингийн талын эсэргүүцэлд Налабородин:

*“Манай ялт ардыг эндээс залхаамой хэмээх бичиг танд илгээсэн танай газраас буцаасан нь, санаваас манай ялт ардыг залхаасныг сонсч мэдэхгүй биеээ хийн буцаасан нь болвоос, манай газраас урьдаас мэдтүгэй хэмээн бичиг илгээсэн буй байтугай танай газраас зарагдсан занги, хотон хоёроос бус ч олон иргэн хятадууд манай ялт ардыг залхаахуйг үзэв. Манай газраас ялт ардыг залхааж дуусмагц даруй өчигдөр манай газраас тэднийг Орос улсын холдахь мужид цөлж халдуулан зовлон албанд заруулав. Танай урьд Гэмпил, Халзанхүү хулгайчнарын хэрэг шийтгэснийг гэвээс, танай их журган ялт хүний амь хэлтрүүлэн таслах оронд хүндэд яллаж шийтгэвээс бас болмой. Манай их императрица үл явуулах хэмээх явдалгүй. Эдүгээ эд хулгайчнарын хэргийг шийтгэж дууссан хэрэг болов.”*¹²

гэсэн хариу өгсөн бөгөөд Тэнгэрийн тэтгэсэн хаан энэ хэргийг мэдсэн даруй зарлиг буулган Хиагтын худалдааг шууд зогсоож хятад худалдаачдыг Эг, Сэлэнгэ, Ерөөгийн газраас хойш харуулын ойр очуулахгүй цаазалжээ¹³. Түүгээр зогссонгүй Түшээт ханы шууд харьяат гөрөөчин отгийн ардуудыг харуулын ойр суух тул элдэв хэрэг дэгдээж болзошгүй хэмээн нутгийг нь урагшлуулан Сэлэнгэ голын хойт этгээдэд суулгажээ.¹⁴ Оростой хил залгах халхын олон хошуудын нутагт харуулын нутгаас наагуур давхар цагдаа өрхүүдийг суулгаж хятад худалдаачид харуулын ойр очиж худалдаалах явдлыг сэргийлүүлжээ. Бас Оростой зах нийлсэн харуулд орос харуулын зүг мэнд мэдэн явахыг хориглож орос нар элдэв хэргийн учир ирвээс Улалзай нарын хэргийг шийтгээгүй цагт хэрэг хэлэлцэхгүй хэмээн шууд үлдэн явуулахыг тушаажээ.¹⁵ Хэрэгт холбогдсон тэргүүн ялт урианхай Жамц нарыг оросууд Улалзай нарыг цаазаар авч шийтгэтэл Хүрээнд хорьсон бөгөөд тэднийг дагалдан харуул гарч хариад нартай харилцан явсан бусад урианхай нар болон тэднийг дураар тавьж явуулсан Уйлган харуулын цэрэг онгорхой Цэвэг нарыг

¹² М-1, Д-1, хн-3106, х.12

¹³ М-1, Д-3, хн-49, х.5

¹⁴ М-1, Д-1, хн-395, х.126

¹⁵ М-1, Д-1, хн-395, х.21

муу агаарт Хунань, Юннань, Гуандун мужийн газар цөлж шийтгэсэн нь бараг бүгд цөлөгдсөн газар очоод удалгүй өвчнөөр нас баржээ.¹⁶

2. Хиагтын худалдааг зогсоосон ба Орос-Чингийн хэлэлцээр

Гадаад Монголын төрийг засах явдлын яам Улалзай нарыг шийтгэсэн тухай мэдээг авмагц Оросын Сенатад бичиг явуулж энэ мэт хэрэг шийтгэж чадахгүй губернаторыг халуулах ба Чингийн тал Улалзай нарыг урьд 1768 онд нэгэнт хэлэлцэж тогтоосны дагуу мөн захын газар цаазаар авч шийтгэхийг шаардав. Сенатаас Улалзай нарыг оросын хууль ёсоор нэгэнт шийтгэж барсан тул нэг хэргийн учир хоёр дахин шийтгэх хуульгүй, харин танай яамнаас чадвартай сайн түшмэлийг гаргаж энэ тухай хэлэлцүүлбэ гэх зэргийн хариу өгчээ¹⁷. Оросууд мөн Чин улс хилийн худалдааг хаавал, Чингийн харьяат хэн боловч хилээр гарч ирэхэд саад хийхгүй гэж мэдэгдээд үүний хажуугаар Чин улстай хил залгаж байгаа газрыг батлан хамгаалах хүчийг нэмэгдүүлэх нууц удирдамж Сибирийн захиргаанд хүргүүлжээ¹⁸. Гадаад Монголын Төрийг Засах Явдлын Яамнаас Сенатад бичиг явуулж урьдын адил Улалзай нарыг захад авчирж цаазаар аван шийтгэх ба зөвхөн ингэсний дараагаар тогтоосон гэрээнд өөрчлөлт оруулж болох юм гээд, монгол болон хятад нар зуу илүү жил манжийн захиргаанд байж нэгэнт Чин улсын харьяат иргэд болсон улс Орост дагах ямар ч санаагүй хэмээн явуулжээ. Энэ хооронд худалдааг бүрэн зогсоож хилийн харуулуудыг оросуудтай ямар ч хэрэг хэлэлцэхгүй болгон шийтгэж энэ тушаалыг зөрчсөн хэнийг ч болов хүндээр яллаж байв. Жишээлбэл, ТТ 50(1785) оны 8 сард, Түшээт ханы чин ван Цэвэгдоржийн хошууны занги Шаравын сумны Төрмөнх тэргүүтэй гурван ард Эрээнцалам харуулаар нууцаар хил гарч гөрөөчлөн явахдаа оросын 5 морь хулгайлж ирснийг тус харуулын тайж Сандув мөрдөн барьж, орост *"ихэмсгийг үзүүлэн"* буцааж өгсөн бөгөөд Сандув нарыг шийтгэх гэсэн Юндэндорж нарыг буруушааж харин хөхүүлэн шагнаад Төрмөнх нарыг муу агаарт газарт цөлж явуулжээ¹⁹. Мөн тэр 8 сард Оросын талаас зам төөрөн харуулын цэрэгт баригдсан Кударинск буюу Хүдэрийн шивээний цэрэг Михайл монгол хэл мэдэхгүй тул Хүрээнд илгээж тэмдэглэх түшмэл Бадакшанаар²⁰ хэлмэрчлүүлэн байцаасанд,

¹⁶ М-1, Д-1, хн-395, х.123-129; М-1, Д-3, хн-49, х.6; М-1, Д-1, хн-395, х.177

¹⁷ Курц Б. Г. Русско-китайские сношения в XVI, XVII и XVIII столетиях. —Харьков, 1929. с.321

¹⁸ Курц Б. Г. Русско-китайские сношения в XVI, XVII и XVIII столетиях. —Харьков, 1929. с.322

¹⁹ М-1, Д-1, хн-3102, х.3

²⁰ Гадаад монголын төрийг засах явдлын яамны тэмдэглэх түшмэл Бадакшан ойрад хүн.

Зүүнгарын Даваачийн харьяат, Зүүнгарыг мөхөхөд Орост ойн гарч үнэн алдартны шажинд орсон бөгөөд 1764 онд Хиагтаас босон ирж Чинд дагаар орсонд, түүнийг орос хэл мэдэх тул тэмдэглэх түшмэл болгон хэрэглэжээ.

“mini tehe kudarizke sere bade uheri minggan isire cooha bi, emu potpolkowunik tefi kadalajahi, ere cooha oci, teci bisirengge, umai ice tebhengge waka, kudarizke sere ba kiyagtu ci tanggu hashan isire ba sandalabuhabi”

“миний суусан Кударичкэ хэмээх газарт бүгд мянга хүрэх цэрэг буй. Нэг подполковник [дэд хурандаа] суун захирчухуй. Энэ цэрэг болвоос уулаас байсан, огт шинэ суулгасан нь бус. Кударичкэ хэмээгч газар Хиагтаас зуун мод хүрэх газар алсалжухуй”

гэх зэргээр өчсөн бөгөөд түүнийг Хүрээнд хэргийг шийдэж бартал урьд баригдсан Боргил, Содов нарын хамт хориулжээ.²¹ Оросын харьяат нар худалдаа хааснаас хойш өргөн хэрэглээний барааны хомсдол орж Чингийн харуулд олонтоо ирж цай, тамхи худалдахыг гуйвч хааны зарлиг ёсоор тэднийг шууд хөөн явуулж, - Улалзай нарын хэргийг хурдан шийтгэж явуулах хэрэгтэй хэмээн хэлүүлж байв. Жишээ болгож, Хүдэр харуулын зангийн айлтгалыг дор үзье.

“uyun biyai juwan uyun i yamjishūn oros baci ilan moringga niyalma, emu sula morin be kutuleme isinjiha de, fonjici ce gemu kiyagtu i hanci cuku birai amargi narin kundui sere bade tehe buriyat niyalma, emu lama gebu isi, juwe kara niyalma, emke gebu burin, emke gebu wangcuk sembi, ilan buriyat uhei mahala gaifi doro arame, hendume, meni bade cai dembegu baharakū de umesi gacilabuha ne (fulgiyan fi – ainci cenі cendegušerengge tere) amba enduringge han i kesi de jalbarime, majige cai dembegu baime bahara jalin, morin emke, odoneo jafu ilan defelinggu mahala weilere hailun suku uyun farsi, toholon emu farsi, enggemu emke gajiha seme gisurehe, taiji, janggin meni gisun, suweni ere jergi jaka be meni bade hihalara ba akū suwe ainu doro giyan be ulhirakū, suweni ubiyacuka hūlha ulaljai sei baita be giyan wayan i icihiyahakū turgunde hūda be yaksiha bime, aiseme meni jecen be dabafi uttu darakūi baime soime yabumbi, jai jici urunakū suwembe jafambi seme dengsime gisurefi janggin mangji bi duin cooha gaifi bašame maribuha sehe seme boolanjihabi”²².

“[1785]Есөн сарын арван есөнд үдэш орос газраас гурван морьтой хүн нэг сул морь хөтлөн ирсэнд асууваас тэд цөм

²¹ М-1, Д-1, хн-3106, х.28

²² М-1, Д-1, хн-423, х.137

Хиагтын ойр Цөх голын хойт Нарийн хөндий хэмээх газар суусан буриад улс. Нэг лам нэр нь Иш, хоёр хар хүн, нэг нь нэр Бүрэн, нэг нь нэр Ванчиг хэмээмөй. Гурван буриад бүгд малгайг авч ёсыг барин мөргөж, манай газарт цай тамхи олдохгүйд маш гачигдав.(улаан бийрээр цохолсон –лав тэдний тэнсэлхийлсэн нь тэр) Одоо их богд хааны хишигт залбиран бага цай тамхи эрэн олохын тулд морь нэг, одончуу эсгий гурван энтэй, малгай үйлдэх халиуны арьс есөн хэсэг, тугалга нэг хэсэг, эмээл нэг авч ирэв хэмээн хэлэлцэв. Тайж, занги манай үг, танай энэ зэрэг юмыг манай газарт үнэлэх явдал үгүй. Та юу гэж ёс зүйг ухахгүй, танай шоодвортой хулгай Улалзай нарын хэргийг зүй зохисоор шийтгэхгүй учирт худалдааг хаасан билээ. Юу гэж манай захыг даван хэдий эрэн явмөй. Жич ирвээс эрхгүй таныг баримой хэмээн дэнсэлгэн хэлэлцэж занги Манж би дөрвөн цэрэг авч үлдэн явуулав хэмээв хэмээн хүрч иржээ.”

Тэр ч байтугай, Хүрээний зүг ирэх оросын элч нарыг өртөөгөөр явах хооронд огт сул хүнтэй яриулахгүй, чанд харгалзан явж Хүрээнд хүргэн ирж байх тушаал гаргажээ²³. Хүрээний сайд Юндэндорж, Сүн Юн²⁴ нар оросууд Улалзайн хэргийг шийдвэрлэхэд баримталж байгаа байр суурийг хариад буюу буриад нарын дунд ямар нэг үймээн дэгдэх вий хэмээн болгоомжилж, байгаатай холбоотой гэж үзэж байв. Энэ тухайгаа Тэнгэрийн тэтгэсэн хаанд дараах мэт айлтгажээ.

“nadan biyai orin jakūn de aha yun, sung, sun gingguleme wesimburengge donjibume wesimbure jalin, jakan kiyagtu de tehe ejeku hafan i jergi yungling ni baci. kiyagtu i oros porocuk ceni tolmaci inat be takūrafi, musei jaisang sei saimbe fonjime, boora karun de ceni juwe niyalma ebsi tulenjihe songko bisire gese seme holdome buksuri alanjaha be, yungling ulame jaisang sede tacibufi giyan be jafame mohobume ulhibuhede, tolmaci emu jergi bekderefi amasi mariha, boora karun i šurdeme bade baici umai

²³ М-1, Д-1, хн-3186, х.34

²⁴ Монгол шулуун цагаан хошууны монгол хүн. Тэнгэрийн тэтгэсэн хааны шадар итгэлт хүн бөгөөд зориуд орост холбогдсон энэ хэргийг шийтгүүлэхийн тулд, ял олж халагдан буцсан Лэбүүгийн оронд Хүрээнд ирж суужээ. Улалзайн хэмээгдсэн энэ хэргийг Оростой нийлж шийтгэсэн ба Монголын тухай тэмдэглэл бичсэнийг нь бид энд хараахан олж үзэж завдсангүйгээ тэмдэглэе.

tulenjihe oros niyalma akū seme ceni sanat yamun i bithe kemuni isinjire unde babe suwaliyame boolanjiha, dahaduhai karun be kadalare jasak erincindorji i baci, ere baitai jalin niyalma takūrafi boora karun de narhūšame baicame tuwabufi umai songko akū seme inu boolanjiha, ere manggai koimali oros hafirabufi kanagan jorime niyalma takūrafi hūda neire muru bisire akū be mejigešeki sere gūnin, yunglin emkeri jaisang sede tacibufi mohobume ulhibufi maribuha be dahame, sirame oros sa jai kanagan jorime niyalma takūranjici jaisang se uthai oros i baru suwe uttu hafirabufi kanaga arame mejigešeme jidere anggala, hūdun ulaljai sebe icihiyafi hūda neire be baici, suwende labtu tusa kai sere gisun i ulhibufi oros ai sehe babe boolanjikini seme yungling de afabume yabubuha, ahasi kimcime gūnici, oros sanat yamun i bithe sidabuhangge, ainci hūlha ulaljai sebe ce gelhun akū ujeleme icihiyarakū de manggašaha ci banjinagangge, turgun oci, ulaljai se umai ceni oros giranggi niyalma waka, gemu jecereme tehe monggo giranggi hariyat i jergi urse, teci baicafi, ere ulaljai hono hariyat i susai boigon be kadalara emu tede niyalma bihe. hariyat se inu ceni buriyat i adali suwayan šajin be wesihulerengge labtu, oros i hūlhi gūnin de, aika ulaljai sebe ujeleme icihiyaci, embici jecereme tehe ulaljai sei adali hariyat i jergi urse, gemu torgūt sebe alhūdeme, muse de dahanjire ayuu seme gūnifi (fulgiyan fi — uttu tere) tutu geleme manggašara be boljoci ojurakū, akūci, gūsin ilaci aniya ceni komisar ginggun ijishūn i musei afabuha be dahame toktobuha kooli be ce ai gelhun akū uthai halaki sembi. geli ai encehen de baita be emdubei jibgešeme aliyakiyambi, amba muru ulaljai sebe gelhun akū ujeleme icihiyarakū babe, iletu gisurere de girume ofi, tukdan buksuri dandame weciheyere be baiha bime, da musei jurgan i bithe be tuwafi gisun baharakū de manggašame, karu bithe benjime sidabuha, tere, eicibe oros emgeri arga mohoho, hon hafirabuha erinde ini cisui baime bithe benjimbi, ere sidande ceni bithe isinjiha be tuwame, ahasi uthai tuwabume wesimbuki, erei jalin suwaliyame gingguleme donjibume wesimbuhe seme wesimbuhede jakūn biyai tofohon de alime gaiha fulgiyan fi i pilehe hese aliyame bici fajiha sehe.²⁵

“[1785]Долоон сарын хорин найманд боол Юн[дэндорж], Сүн [Юн] хичээнгүйлэн айлтгасан нь, сонсгон айлтгах учир, сая

²⁵ М-1, Д-1, хн-423, л.120-122

Хиагтад суусан тэмдэглэх түшмэлийн зэрэг Юнлингийн газраас Хиагтын орос поручик тэдний толмач Инатыг зарж, манай Зайсан нарыг мэндийг асууж, Буур харуулд тэдний хоёр хүн нааш нэвтэрч ирсэн мөр бүхий мэт хэмээн хуурмаглан битүүлэг хэлж ирснийг Юнлин уламжлан Зайсан нарт сурган хэвийг барин мохоон ухуулсанд, толмач нэг зэрэг бэгтрэн хойш одов. Буур харуулын тойрны газар эрвээс огт нэвтэрч ирсэн орос хүн үгүй хэмээн тэдний Сенат яамны бичиг басхүү хүрч ирээдүй газрыг хамтруулан хүргэж ирэв. ... харуулыг захирах засаг Эринчиндоржийн газраас, энэ хэргийн учир хүн зарж Буур харуулд нарийвчлан байцаан үзүүлтэл огт мөр үгүй хэмээн мөн хүргэж ирэв. Энэ зусар орос хавчигдаад шалтаг заан хүн зарж худалдаа нээх байдал бүхий үгүйг мэдээчилсүгэй хэмээх санаа. Юнлин нэгэнтээ Зайсан нарт сурган мохоон ухуулж явуулсаныг даган, дараагаар орос нар жич шалтаг заан хүн зарж ирвээс Зайсан нар даруй оросын зүг, Та ийн хавчигдаад шалтаглан мэдээчлэн ирэх байтугай, хурдан Улалзай нарыг шийтгэн худалдаа нээхийг эрвээс, танд үлэмж тус болой хэмээх үгийг ухуулан орос юу хэмээсэн газрыг хүргэж иртүгэй хэмээн Юнлинд тушаан явуулав. Боолчууд хянан санаваас, орос сенат яамны бичиг хождуулсан нь, лав хулгай Улалзай нарыг тэд аймшиггүй хүндээр шийтгэхгүйд бэрхшээснээс ... нь, учир болвоос, **Улалзай нар огт тэдний орос ястай хүн бус, харин захлан суусан монгол ястай хариадын зэрэг ард.** Угаас байцааваас, энэ Улалзай бас хариад тавин гэрийг захирах нэг дарга хүн бөлгөө. **Хариад нар мөн тэдний буриадын адил шар шажныг эрхэмлэсэн нь үлэмж.** Оросын мунхаг санаанд, хэрэв Улалзай нарыг хүндээр шийтгэвээс, магадгүй захлан суусан Улалзай нарын адил **хариадын зэрэг ард цөм торгууд нарыг дуурайж, манайд даган ирэх буюу хэмээн санаж (улаан бийрээр –маш мөн)** тийнхүү эмээн эргэлзэхийг болзвоос болохгүй. Үгүй бол гучин гуравдугаар он тэдний комиссар хичээнгүй эевэргүүгээр манай тушаасныг даган тогтоосон хуулийг тэд ямар аймшиггүй даруй халсугай хэмээмэй. Бас ямар чинээнд хэргийг байн байн чавхуурхан хүлгэлзмэй. Байдал нь Улалзай нарыг аймшиггүй хүндээр шийтгэхгүй газрыг илэрхий хэлэлцэхэд ичих тул, ... битүүлэг тандан ...-ыг эрсэн бөлгөө. Эдүгээ манай яамны бичгийг үзээд үг олдохгүйд ичиж, хариу бичиг илгээн

хождуулав. Тэр эсвэл орос нэгэнт арга мохов. Маш хавчигдсан цагт түүний дураар эрэн бичиг илгээмой. Энэ удаад тэдний бичиг хүрч ирснийг үзэж боолчууд даруй үзүүлэн айлтасугай. Үүний тул хавсарган хичээнгүйлэн сонсгон айлтгав хэмээн айлтгасан найман сарын арван таванд тосон авсан улаан бийрээр цохолсон зарлиг хүлээн байваас барав хэмээв.”

Оросуудын хувьд Чингийн хатуу байр сууринаас нилээд сүрдэж байсан бололтой, хилийн хамгаалалтыг сайжруулахаар хичээжээ. Европын хэсгээс цэрэг татаж суулгах боломж мөн л хязгаарлагдмал байсан тул нутгийн уугуул иргэдийг энэ албанд уриалав. Хорь буриадын ахлагч тайш Иринцев 1785 оны есөн сард Эрхүүгийн губернатортай уулзахдаа хорийн 11 отгоос нийт 2500 цэрэг гаргаж хоол хүнс, зэр зэвсэг ба унаа мориор хангахаа бичгээр амалжээ. Эднээс 1000-ыг нь Хиагтаас 120 мод газрын зайтай Түгнүй голд, 500 хүнийг Энгидэй голд, 500 хүнийг Ононд, 500-г Боорж, Түргэн голуудад суулгахаар шийдвэрлэсэн бөгөөд Чингийн талаас дайны үйл ажиллагаа эхэлсэн тохиолдолд л энэ чиглэлээр очих ёстой, тэр болтол өөрийн нутагт хуучин хэвээр сууж байхаар тушаажээ²⁶. Энэ мэтээр хоёр тал өөрийн байр сууринд хатуу зогссоор нилээд хэдэн жил өнгөрсөн бөгөөд Чингийн тал энэ хооронд хятад худалдаачдыг харуулын ойр очихыг хатуу чандлан цаазалж харуулын цэргүүд оросын зүг худалдаа хийсэн нь мэдэгдвэл хатуу шийтгэж байв. Жишээлбэл, Тэнгэрийн тэтгэсний 52-р онд (1787) Түшээт ханы жүн ван Доржжавын хошуунаас Сэцэн ханы Хиргун харуулд суусан залан Жаргал Оросын Минж харуулын урьд таних орос Казанцеваас морь арилжин авч явсныг илрүүлэн түүнийг муу агаарт газар цөлж, холбогдсон хүмүүсийг бас хүнд яллажээ²⁷. Оросоос дагаар ирэх буюу босч ирсэн хүмүүсийг хэрэглэх ард болвоос нийслэлд илгээж хэрэглэхгүй хүн бол ихэмсгийг үзүүлэн орос нарт хойш тушаан өгч байх зарлиг гарсан тул Оросоос хил даван орж ирсэн босгуулуудаас оросын тухай мэдээ баримт сэлт цуглуулж байв²⁸. Тэдгээрийн нэг Самба хэмээх буриад босгуул 1788 оны 7 сард Уйлган харуулаар ирж Улалзайгийн тухай дараах зүйлийг ярьжээ.

“...ceni buriyat ursei dorgi cai dembegu gemu lakcaha turgunde
hülha ulaljai be toome ceni cagan han be gasambi sembi. ... geli

²⁶ Васильев А.П. Забайкальские казаки. Т.2. Хабаровск. 2007, с.243-244

²⁷ М-1, Д-1, хн-423, х.55

²⁸ Жишээ нь, 1789 оны 2 сард Тарвагатайн газар Бургастай харуулаар орж ирсэн орос эр Алексейг байцаагаад 2 жил гаран хасагийн олзонд байсан тул оросын дотоод хэргийг мэдэхгүй асар хэрэглэхгүй хүн хэмээн орост Хиагтаар дамжуулан буцааж өгчээ. М-1, Д-1, хн-3186, х.46

hülha ulaljai meni emu buriyat niyalmai sasa falabuha baci ukame
meni buriyat i bade emu mudan isinjiha be meni bade utu niyalma
sabufi tere buriyat niyalma be miyoocalame ulaljai i sasa jafafi
dasame falabure jukün i unduri ulaljai bucehe ini giran be emu sejen
i acigan moo udafi teijihe seme donjiha sembi.”²⁹

“...тэдний буриад ардын дотор цай тамхи цөм тасарсан учирт
Улалзайг харааж тэдний цагаан хааныг гасалмой хэмээмой. ...
Бас хулгай Улалзай манай нэг буриад хүний хамт цөлөгдсөн
газраас босч манай буриад нутагт нэг удаа хүрч ирснийг манай
газарт хэдэн хүн мэдэж тэр буриад хүнийг буудаж Улалзайн
хамт барьж дахин цөлөх замд Улалзай үхсэн. Түүний ясыг нэгэн
тэрэг ачааны мод худалдан авч түлсэн хэмээн сонссон
хэмээмой.”

Чингийн тал ийнхүү Самбаас Улалзайн үхсэнийг мэдсэн боловч мөн
Улалзайг цөллөгийн газарт нас барсан хэмээн явуулсан Эрхүүгийн шинэ
губернатор Арсентьевын бичгийг няцааж итгэхгүй хэмээн 1788 оны эцсээр
хариу бичиг явуулжээ.

“... Улалзай болвоос түүний гэмийн тулд хол газарт цөлж
явуулсны хойно, нэг жилээс илүү болж үхэв хэмээн бодвоос
түүний буруу хийсэн нь мөн ястайгаа хамт өнгөрөв, хэмээсэн нь
энэ үг зүйд нийлэхгүй, юув гэхүл, та язгуураас хуучин хуулийг
дагаж хулгайч нарыг манд үзүүлэн цаазаар алсангүй, цөлж
шийтгэсэн нь даруй буруу болсон бөгөөтөл, энэ нэгэн хэрэг мөн
огт Улалзай нэгэн хулгайчийн төдий бус агсан билээ. Улалзайн
адил цавчиж алваас зохих танай хариадын Эрбэнэй, Хашига,
Мэхэйтү гурван хулгайч буй бөгөөд басхүү цавчирга жанчваас
зохих Мэнд, Болдон хоёр дэд хулгайч буй бишүү. Мөн Улалзай
үнэхээр үхсэн гэвээс гагцхүү түүний нэгэн хүний ял дууссанаас
бус Эрбэнэйн зэрэг хулгайч нарыг захад авчирж уг тогтоосон
хууль ёсоор бүгдээр үзэж шийтгэвээс зохихгүй хэмээмү үү.
Эдгээрийн дотор нэг хоёр үхсэн болтугай цөмөөр үхсэн
хуульгүй даруй цөм үхсэн хэмээвээс танай үхэх ялтай хүнийг
захын газарт авчирж бид хамт үзэж Улалзайн төлөөнөө цаазаар
алваас бас болох болой.”³⁰

²⁹ М-1, Д-1, хн-3166, х.6

³⁰ М-1, Д-1, хн-435, х.151

Арсентьев түүний хариуд 1789 оны 1 сарын 21-нд дараах бичиг явуулжээ.

“...тэргүүн хулгайч Улалзай болвоос өнгөрсөн нэг мянган долоон зуун наян долдугаар оноо декабрь сарын хорин дөрвөндө [1787.XII.24] Охот (Номхон далайн нэг тэнгис Охотское море-г хэлж буй бололтой-зох.) газарт үхэв хэмээснийг бас ч түүнд нөхөрлөсөн Эрбэнэй нөхөстэй болвоос мөн Улалзай ч болов цавчин алахын оронд хэмээвч манай Орос гүрэн дотор манай их өршөөнгүйт императрица ивээсэн цаг дотор цавчин алах хуульгүй тулд үүнд адил болгож хэдэн хол газарт цөлж нас нь дуустал тэсэхгүй зовлонд зарав. ...хуучин найртайгаар болгож хураасан хоёр гүрэнд тустай маймаа тавихуйг найдмой.”³¹

Энэ хэргийг ийнхүү шийдвэрлэж ядан байтал хилийн газар мөн тэр Уйлган харуулын залгаа зүүн талын Дархинт харуулд бас нэгэн хэрэг үүсэн гарч байдлыг улам төвөгтэй болгожээ. 1789 онд Хүрээ сайдаас хаанд өргөсөн айлтгалд энэ тухай:

“...anagan i sunja biyai tofohon de darkintu karun i cooha hündaga se karun tule hanci šurdeme gurgušeme yabure de kaici jukūn i amargide utu niyalmai songko bisire be sabufi, amasi jifi, karun i taiji, janggin de alaha, janggin samdan uthai cooha cibak sebe gaifi karun tucifi songko dahalame baicame genehe songko goro ofi, cooha coimpil, angka juwe niyalma karun ci kunesun gaifi amcame benehe, ere karun bakcan oros karun ci utu inenggi on goro sandalabuha bime, sidande alin buyan šuwa ukda canggi ofi, janggin samdan cooha cibak se songko dahalame tehi susai ba gese yabufi alin mulu ci wasihūn gaitai jakūn buriyat bisire be sabufi ainarangge seme fonjici, umai jilgan tucirakū ilan buriyat wesihūn ici miyoocilame jakade, janggin samdan se karu miyoocilame jabduhakū durbefi jailaha cooha cibak teile miyoocan goifi bucehe, cibak i miyoocan morin be buriyat inu gamaha, dahaduhai kunesun benere coimpil, angka yabume isinafi seremšehekū de angka i yaluha morin bethe de miyoocan goifi dohošoho ninggun buriyat borhome jifi angka i jadaha jerde morin, loho, gida, coimpil i miyoocan jerde morin, jai kunesun honin i yali mucen be

³¹ М-1, Д-1, хн-453, л.13-14

yooni durime gamaha, cibak i keire morin be buriyat kutuleme gamaha be angka sabuha, buriyat sa gemu buyan šuwa de dosifi, baime baharakū ofi, janggin samdan, cooha coimpil, angka i jergi juwan niyalma casi songko afabume mutehakū.³²

“...илүү таван сарын арван таванд Дархинт харуулын цэрэг Хундага нар харуулын гадна ойр тойрон гөрөөчлөн явахад хайчийн замын хойно хэдэн хүний мөр бүхийг мэдэж хойш ирж, харуулын тайж, зангид хэлэв. Занги Самдан даруй цэрэг Цэвэг нарыг авч харуул гарч мөр мөрдөн байцаан одов. Мөр хол тул, цэрэг Чоймпил, Анх хоёр хүн харуулаас хүнс авчруулахаар илгээв. Энэ харуулын барьцаа орос харуулаас хэдэн өдөрийн зайтай хол алсалсан бөлгөө. Хооронд уул бургас шугуй л буй тул занги Самдан цэрэг Цэвэг нар мөр даган дөч тавин газар явж, уул нуруунаас доошлоход гэнэт найман буриад бүхийг үзэж, - Юун хэмээн асууваас, огт дуу гаргахгүй гурван буриад дээш одож шууд буудсанд, занги Самдан нар хариу буудаж завдсангүй, дүрвэн зайлав. Цэрэг Цэвэг ганцхан буунд оногдож үхэв. Цэвгийг буу морийг буриад мөн авав. Хүнсэнд илгээсэн Чоймпил, Анх яван хүрч сэрэмжилсэнгүйд Анхын унасан морины хөлд буу тусч доголов. Зургаан буриад баглан ирж Анхын зээрд морь, илд, жад, Чоймпилын буу, зээрд морь, жич хүнс хонины мах, тогоог бүрэн дээрэмдэж авав. Цэвэгийн хээр морийг буриад хөтлөн явсныг Анх харсан. Буриад нар цөм бут, шугуйд орж эрэн олдсонгүй тул, занги Самдан, цэрэг Чоймпил, Анхын зэрэг арван хүн цааш мөр тушаан чадсангүй.”

Оросууд тэднийг оросын харьяат биш Чингийн харьяат монгол хэмээн мэлээж магадгүй, бас харуулын ойролцоох монголчууд үнэхээр дээрэм хийсэн байж болзошгүй хэмээн тэдгээр занги цэргүүдийг чандлан байцаахад, “хулгайн өмсөх хувцас буриад адил байж, цэрэг Чоймпил хараахад буриад харин орос үгээр хариу хараасан бөлгөө” гэснийг баримтлан энэ тухай Арсентьевт бичиг явуулж хэргийн тухай мэдэгдээд нэн даруй шийтгэж өгөхийг шаарджээ. Чингийн “харуулын цэргүүд” хилийн ойр “харуулын дотор явж байсан” 1 орос, 3 буриад нарыг барьж авч, Цэвэг нарын ясыг үзүүлэн тэмдэг болгожээ³³. Гэтэл харин губернатор, “Чингийн талаас 50 цэрэг ирж оросын харуулын

³² М-1, Д-1, хн-453, л.101-105

³³ М-1, Д-1, хн-453, л.106

цэргийг баривчилсан”³⁴ хэмээн буруутгаад энэ хэргийн доторх хулгайч нарыг хоёр улсын эв найрыг бодон эрүүлэвч олдохгүй байгааг 1789 оны 9 сарын 15-нд явуулсан бичигтээ бичжээ³⁵. Юндэндорж хаанд айлтгал өргөн хил дээр баригдсан буриад нарыг захын газар Хиагтад аваачиж нэгийг нь Улалзайн оронд, нөгөөг нь Цэвэгийн оронд цаазалж амь төлүүлэе гэсэнд Тэнгэрийн тэтгэсэн хаан, “энэ цом Сүн Юн тэнд удаан сууж гэрийг санан, энэ аргыг бодож гарган, хааш ийш хэрэг шийтгээд, нийслэл хотонд одохыг хичээх нь илт” хэмээн буруушаажээ³⁶. Нэгэнт хаанаас ингэж шийдвэрлэхийг зөвшөөрсөнгүй тул Хүрээ сайдын газраас губернаторыг шахаж хэрэгтнийг олуулахаар чармайв. 1790 оны эхээр билгийн тооллоор цагаан сарын 27-нд Эрхүүгийн губернатор Хүрээ сайд нарт бичиг илгээж хэрэгтнүүдийг барьснаа мэдэгджээ.

*“Цэвэгийн хэргийн хүний нэр Дабадай Харанхайн, Хашираг Гүнгэ-гийн, Махурска Данжигийн. Эдний хилийг алхваас, Тураны харуулд Харбиенхү хэмээгч горхийн эхэнд явж, хилийн газраа хатуу чулуутай тул, мөр нь үзэгдсэнгүй амой. Цэвэгийг буудаж алсан нь үнэн. Гурван морь, хоёр буу, нэг жад, нэг сэлэм, хоёр хонины мах, нэг зэс тогоо аваачсан нь ийм зэргээр танай Дархинтын харуул хүн тэднээр уулзаад нум дэлж, буугаа мяраан эргүүлсэнд тэд айж хариуд буугаа буудаж Цэвэгийг шархдан үхүүлэв. Түүний уулзаж дээр бичсэн морь юмыг булааж авбай.”*³⁷

Цэвэгийн хэргийг үйлдсэн хүмүүс баригдсан тул Чингийн тал барьж аваачсан харуулын гурван хүнийг буцааж өгөхийг шаардаад энэ хэргийг зах Хиагтын газар шүүж худалдааг сэргээхийг хүсчээ. Тийм учир Хүрээний газраас сайд Сүн Юн мордож Хиагтын газар очоод Оросын талаас гаргасан подполковник, майор хоёртой хэлэлцэж шүүв. Оросууд урьдын адил хэрэгтнүүдийг цаазаар авч шийтгэхгүй, харин кнут хэмээх ташуураар жанчиж амьд үлдвэл цөлж явуулна гэсэнд, Сүн Юн нар 1768 онд тогтоосон нэмэлт зүйлийг хөдөлгөхгүй тэр ёсоор шийтгэнэ хэмээж хаанд оросуудын энэ мэт

³⁴ Оросын талын буруутгасанчлан Чингийн талаас оросын харуулын цэргийг хил гаран очиж баривчлан авчирсан бололтой. Энэ явдалд эфү Юндэндорж, Да бэйс, түшээт хан Цэдэндорж, чин ван Цэвэгдоржийн хошууны түшмэл цэргүүдийг гаргаж орос буриад нарыг бариулсан ажээ. М-1, Д-1, хн-3186, х.50

³⁵ М-1, Д-1, хн-453, л.133-138

³⁶ М-1, Д-1, хн-453, л.153

³⁷ М-1, Д-1, хн-464, л.16-17

аашлах нь буриад нар торгуудын адил Чинд дагаар оруузай хэмээн болгоомжилсноос болсон гэж урьдын адил үзэж байгаагаар айлтгажээ.

“gūsin ningguci aniya ceni jecen dolo bisire utala tumen boigon
torgūt urse hing seme enduringe ejen i gosin fen de forome
dahanjifi, enduringe ejen kesi isibume dalaha torgūt sebe han wang,
beile beise gung jasad taiji i hergen jergi šangname fungnefi, sain
nukta jorime bahabufi, jirgame tebuhe turgunde, oros sa umesi
geleme ceni jecereme tehe buriyat hariyat urse gemu monggo
giranggi suwayan šajin be wesihulerengge umesi labdu ofi, oros i
hūlhi gūnin de aika nenehe ulaljai ce dabada i sebe de toktobuha
kooli songkoi sacime wara oci, buriyat hariyat sa leksei torgūt be
alhūdame musede dahanjire ayoo seme tuttu emu umesi fa akū hūlhi
arga daribufi niyalma be warakū sere tantame icihiyafi falabuki sere
gisun i hūlhidame kanagan arame giyangnambi.”³⁸

“[Тэнгэрийн тэтгэсний] гучин зургадугаар он [1771] онд тэдний зах дотор бүхий олон түмэн өрх торгууд ард чин хэмээн Богд эзний өршөөл соёлд хандан дагаар ирж, Богд эзэн хишиг хүртээн тэргүүлсэн торгууд нарыг хан, ван, бэйл, бэйс, гүн, засаг тайжсийн хэргэм зэрэг шагнаан хохүүлж, сайн нутаг заан олгуулсан, жарган суулгасан учирт, орос нар маш гэлмэн тэдний захиан суусан буриад хариад ард цөм монгол ястай шар шажныг эрхэмлэсэн нь маш үлэмж тул, оросын мунхаг санаад хэрэв урдах Улалзай эдүгээх Дабадай нарыг тогтсон хууль ёсоор цавчин алах болвоос, буриад хариад нар хотлоор торгуудыг дууриан бидэнд дагаар ирэх буюу хэмээн тийнхүү нэг маш үнэргүй мунхаг арга гаргаж хүний алахгүй хэмээх жанчин шийтгэж цөлсүгэй хэмээх үгийг мунхагдан өршөөл эрэн тайлбарламой.”

Сүн Юн хэрэг нэгэнт сунжирч удсан бас энэ хооронд оросуудын барьж авчирсан “хэрэгтэнүүд” өвчнөөр үхэж цааш улам түвэгтэй байдал үүдэхээс “сэргийлэн” Тэнгэрийн тэтгэсэн хааны 1784 онд оросын талын хэрэгтнүүдийг цавчиж алахын оронд жанчуулж үхүүлэхийг зөвшөөрнө гэсэн зарлигийг баримтлан ТТ 55-р оны [1790] 3 сарын 8-нд Хиагтын газар хоёр талаас олон зуун хүнийг цуглуулж захын газар авч ирэхэд оросууд тэргүүлсэн хэрэгтэн Дабадайн хувцасыг тайлж том бүдүүн шонгоос гар, хөлийг хүлэн кнут хэмээх бүдүүн ташуураар гурван зуу илүү жанчсанд арьс хуурч унан их л зовлонтой

³⁸ М-1, Д-1, хн-464, л.65-66

үхсэнийг байцаан үзээд Цэвгийн хэргийг шийтгэв³⁹. Оросууд Улалзай болон түүний нөхөр Эрбэнэй цөллөгийн газар нэгэнт нас барсан, Матурши мөн цөллөгт усанд унаж үхсэн тул сая баригдсан Дабадайн нөхөр хоёр буриадыг Улалзайн оронд жанчин шийтгэж хэргийг дуусгая хэмээн гуйсанд Сүн Юн хааны зарлигийг хүлээнэ, дур мэдэн шийтгэж чадахгүй хэмээж буухиа элчээр энэ тухай айлтгаад зарлигийг хүлээлгэжээ. Тэгээд Цэвгийн хэргийн учир баригдсан оросын Шар азарга харуулын орос Порос, буриад Энх, Мөнх гурвыг хойш олгуулжээ⁴⁰. Энэ хооронд оросууд Цэвгийн хэргийн ор арван хувь, ялыг барагдуулж өгөөд үлдсэн хоёр буриадыг мөн кнут-ташуураар жанчиж Улалзайн оронд хэргийг шийтгэе хэмээн удаа дараа гуйсанд Сүн Юн “зөвшөөрч” харин ингэсний хариуд Чингийн тал оросын баригдсан харид Боргил, Содов нарыг суллахгүй гэсэнд оросууд зөвшөөрч хоёр талаас цуглан мөн тэр 3 сарын 12-нд захын газар хэрэгтэн Хашрагийг 300 ташуурдсанд үхэж, нөгөө Мархушаныг мөн адил жанчсанд амьд үлдсэнд энэ шөнө лав үхнэ хэмээн хэлсэн аж. Энэ нь Оросын талаас хэргийг шийдвэрлэхээр хэлбэрэлтгүй зорьсноо Чингийн талд харуулах гэсэн оролдлого байв. Сүн Юн энэ бүх хэргийг Хиагтад очоод долоо хонохын дотор шийдсэн бөгөөд оросуудын хэрэг шийтгэж явуулсны дараа сая хаанд айлтгал явуулсныг Тэнгэрийн тэтгэсэн хаан ихэд буруушааж Улалзайн хэргийг шийтгэснээр тооцож болохгүй хэмээн Сүн Юнг донгодон мэйрэн занги, жигүүрийн сайдын тушаалаас нь ховхолж, дөрөвдүгээр зэргийн түшмэл болгон зэрэг бууруулав⁴¹. Тэнгэрийн тэтгэсэн хааны зарлигаар Сүн Юн Эрхүүгийн губернатортай энэ хэргээр хэлэлцэх эрхээ хасуулж, зөвхөн оросын Сенатаас Гадаад Монголын төрийг засах явдлын яаманд бичиг илгээхийг хүлээн суух болсон бөгөөд губернаторын бичгийг түүнд өөрт нь буцаан илгээх болжээ. Удалгүй Сенатаас Гадаад Монголын төрийг засах явдлын яаманд бичиг ирүүлсний хариуд Улалзай нарын хэргийг шийдвэрлэснээр тооцож харин Улалзай нарын хэргийг буруу шийтгэсэн хуучин губернатор Ламбыг шийтгэсэн тухай мэдэгдэхийг шаардсан бөгөөд энэ бичиг Хүрээнд 1790 оны 3 сарын 15-нд хүрч иржээ. Губернаторын Хүрээ сайдад дагууд нь илгээсэн захидалд:

³⁹ М-1, Д-1, хн-464, л.69

⁴⁰ Энд нэг зүйлийг тэмдэглэхэд энэ гурван хүний энэ нэр тэдний жинхэнэ нэр биш бололтой юм. Учир нь оросын талаас тэдний харуулын цэргийг барьсныг эсэргүүцэж явуулсан бичигт тэднийг *Петр Викулов, Шангин Баиров, Ханхарик Чертагаев, Зодба Хамишеев* гэсэн бөгөөд тэднээс *Шангин Баиров* нь олзноос оргон гарч очсон бөгөөд түүнийг Чингийн талд болохоор *Дорж* хэмээн тэмдэглэжээ. Нөгөө гурав нь ч өөрсдийн нэрийг Чингийн талд хэлсэнгүй бололтой, орос нь өөрийгөө *Порос* хэмээсэн нь оросоор гахайн тоорой гэсэн үг, нөгөө хоёр нь өөрсдийгөө *Энх, Мөнх* гэсэн нь монголчуудын хамгийн түгээмэл нэрээс дураараа хэлсэн мэт аж.

⁴¹ М-1, Д-1, хн-464, х.118

“Амбас би таныг итгэж чадмой. Манай хатан хаан урьдах губернатор Ламбыг захын хэргийн учирт тушаалаас байлгаж хойш аваачсан нь даруй хулгайч Улалзай нарын хэргийн тул мөн. Хууль халах хэрэг, мөн танай Их журганы дурыг дагаж эдүгээ, хоёр этгээд ер тэмцэх явдал үгүй тул, хэрэг цөм дуусваас болмой. Амбас та миний янаг нөхөд тул, янаг нөхдийн тул, миний гуйх нь уламжлан их журганд гуйх ажаамуу. Өршөөлт их богд эзний хишигт Хиагт газраа тустай худалдаа маймаа нээх ба, хорьсон манай хүнийг хойш өгөх дахин хоёр улсын харилцан үүрд найртай болтугай хэмээхийг, Сенат яамнаас гуйсан билээ”⁴²

хэмээн бичсэнийг Хүрээ сайдаас олон харуулын газар илгээн ухуулжээ. Гэтэл бас дахин нэг хэрэг үүсэн гарч худалдаа нээх, харилцааг хэвийн болгох асуудал хойшлогджээ. Ховог сайрт суух торгуудын чин ван Цэрэн-Увшийн харьяат Габан хэмээх Самайрин гэгч лам зам төөрөн хасгийн нутагт орсныг хасгууд орост худалдсанд оросын “Оромдоо” хотны губернатор түүнд нэг лацадсан захидал бичиг өгч суллан буцаан явуулжээ.

Цэрэн-Увш Габанг түүний авч ирсэн бичгийн хамт дээш мэдэгдэн Бээжинд хүргүүлсэн бөгөөд 1791 оны 4 сард Гадаад Монголын төрийг засах явдлын яамнаас тэр орос үсгийн бичгийн хамтаар Оросын сенат яаманд бичиг явуулан энэ хэргийг тайлбарлахыг шаарджээ.

“geli anggai alame, se suweni oros sa juwe bade uheri ninggun tumen cooha isinjifi, ere aniya torgūt sabe gaire jalin afaduki sembi, torgūt se cihangga oci, uthai aisilame sasa afadukini seme alafi, gabang be sindafi amasi unggihe”⁴³

“бас амаар хэлсэн нь танай орос нар хоёр газарт бүгд зургаан түмэн цэрэг хүрч ирж энэ жил торгууд нарыг авах учир дайлсугай хэмээмой. Торгууд нар дуртай болвоос, даруй туслан хамт дайлтугай хэмээн хэлж Габанг тавьж хойш илгээжээ.”

Бичиг Оросын сенатад хүрэхээс өмнө Хиагт болон Эрхүүд суусан орос түшмэлүүд энэ хэрэг зохиомол, Орост Габангийн ярьсан шиг Томск, Омск хэмээх хотууд байх боловч Оромдоо гэх хот байхгүй мөн тэнд губернатор хэргэмтэй хүн суудаггүй гэхчлэн ярьжээ⁴⁴. Оросын сенат энэ хэргийг авч

⁴² М-1, Д-3, хн-59, х.2

⁴³ М-1, Д-3, хн-59, х.39

⁴⁴ М-1, Д-3, хн-59, х.31

хэлэлцээд Габанд орос губернаторын өгсөн гэх бичиг нь маш муу найруулгатай бөгөөд гаднах лац нь ямар ч тамга бус харин энгийн нэгэн зоосны сүлдийг ашиглан дарсан илт хуурамч бичиг тул үүнд анхаарал хандуулах хэрэггүй, Орос улс торгуудыг буцааж авахын төлөө Чин улстай дайн хийх санаагүй байгаа гэдгээ илэрхийлжээ.⁴⁵ Тэнгэрийн тэтгэсэн хаан энэ хэргийг сайтар мөрдөн шалгаж үнэн байдлыг тодруулахаар чандлан тушаасанд Самайрин харин энэ хэргийг зохиосон болох нь илэрчээ.

“samairin jugūn fambufi karun i tule gurguṣeme yabure duin hasak be ucarafi, hasak sa imbe noohai hoise de uncafi, ei noohai hoise be dahalame, oros i om hoton de isinafi, juwe biya tehe, tubade emu kalkai sain noyan aiman i monggo giranggi niyalma andarai be acafi, ishunde gemu monggo giranggi ofi, ei an i oros ci ukcame tucifi weile ci guweki seme andarai de hebeṣefi, andarai inde ne oros sa cooha isafi, torgūt sabe gaire jalin dain dekdeki seme emu afaha oros hergen i bithe bufi gajiha seme alaci uthai simbe weile ararakū oho seme tacibufi, andarai i beye emu oros hergen i bithe arafi inde bufi gajiha seme jabuhabi”⁴⁶

“Самайрин зам төөрч харуулын гадна гөрөөчлөн явах дөрвөн хэсгийг учирч, хасаг нар түүнийг Ноохой хэмээх хотонд худалдаж, Ноохой хотонг даган Оросын Ом [Омск] хотонд хүрч хоёр сар суув. Тэнд нэг халхын Сайн ноён аймгийн монгол ястай хүн Андрейг нийлж харилцан цом монгол ястай тул, оросоос зугтан гарч ялаас хэлтэрсүгэй хэмээн Андрейд хэлэлцэж, Андрей түүнд орос нар цэрэг цуглуулан, торгууд нарыг авах учир дайн дэгдээсүгэй хэмээн нэг байлдсан орос үсгийн бичиг өгч авч ирэв хэмээн хэлвээс даруй чамайг ял хэлэлцэхгүй болов уу хэмээн сургаж, Андрейн бие нэг орос үсгийн бичиг бичиж түүнд өгсөн хэмээн өчжээ.”

Самайрин гэгч ийнхүү дураар хил гарч явсан ялаас мултрахын тулд хэдийгээр ийм хэрэг зохиосон боловч оросууд Монголыг нэгтгэж авах хуучин бодлоо ер нь орхиогүй байсан мэт. Гэхдээ энэ санаачлага голдуу Сибирийн эрх баригчид Монголтой хил залгасан нутгийн орос ноёд Монголын талаар илүү мэдээлэлтэй байсныхаа хирээр энэ мэт төслийг боловсруулан Оросын төв засгийн газарт хүргүүлж байсан боловч дэмжлэг авах нь ховор байжээ. 1756

⁴⁵ Архивъ государственнаго совета. Томъ первый. Советъ въ царствование императрицы Екатерины II. (1768-1796). Санктъ-Петербургъ. 1869. с.650

⁴⁶ М-1, Д-3, хн-59, х.42

онд Халхад бослого хөдөлгөөн дэгдсэн жил Халхыг дагуулан авах төслөө Сенатад танилцуулан зөвшөөрүүлж байсан Сэлэнгийн бригадир Варфоломей Якобийн хүү Эрхүүгийн генерал-губернатор Иван Варфоломеевич Якобий 1791 онд Сенатад Монголыг Хүрээ хүртэл болон Амар мөрөн орчмыг Орост нэгтгэх төсөл оруулжээ. Тэрбээр 20 мянган явган цэрэг, 10 мянган морьт цэргийн хүчийг энд төвлөрүүлэн, Хиагт болон Нэвчүүгийн чиглэлээр цохилт өгч эзлэхэд Хиагтаар дайран Хүрээний чиглэлд 14 мянган явган цэрэг 7 мянган морьт цэрэг, Нэвчүүгээр 6 мянган явган цэрэг 3 мянган морьт цэрэг оруулах бөгөөд буриад хамниган нараас 10 мянган цэрэг татаж энэ дайнд нэмэрлэнэ хэмээн төсөвлөсөн байв.⁴⁷ Гэвч энэ санал нь Сенатад дэмжигдсэнгүй, Орос улс Европын бодлогодоо анхаарлаа түлхүү хандуулж, зардал ихтэй тэгээд ч эрсдэлтэй энэ төслийг хүлээн авсангүй. Хүрээ сайд Юндэндорж нар ч торгууд лам Самайрины ярьсанчлан оросууд дайн үүсгэж Хиагтын зүг довтлон ирвэл халхын цэрэг дуртайяа тэргүүнд явж гавьяа байгуулна гэхчлэн айлтгал өргөжээ.

“...bahaci, ejen de hūsun akūmbuki waššaki sere gūnin umesi hing sembi, talude oros šumin dosinjici, muse jirgambi, tere suilambi, jirgacun i suilacun be gidara de ja bime, ahasi uthai jukūn i juwe dalbakici giyalan giyalan i buksime tucifi šalame hafitame afaha de oros sa jabšan bahame muterakū sere anggala, ukame mariki seci inu mutarakū ombi, te enduringge ejen uttu jakanjame tacibuha de, ahasi umesi fakjin bahame ofi hese be dahame jenduken i jebklere jalin, ahasi uttu narhūšame bodofi, urunakū olhošoho”⁴⁸

“...Олдвоос, эзэнд хүчин гүйцэтгэсүгэй зүтгэсүгэй хэмээх санаа маш чин хэмээмой. Хэрэв орос гүн орж ирвээс бид жаргамой. Тэд зүдэрмой. Жаргалаар зүдрэлийг дарахад хямд бөлгөө. Боолчууд даруй замын хоёр талаас зай зайтай бүгэн гарч шаламгайлан хавчин дайлахад орос нар завшаан олон чадахгүй хэмээх байтугай оргон одсугай хэмээвч мөн чадахгүй болмой. Эдүгээ Богд эзэн ийн завсарчлан сургасанд боолчууд маш тулгуур олох тул зарлигийг даган сэмээрхэн зэвсэглэх учир боолчууд ийн нарийвчлан бодож эрхгүй болгоомжлов.”

Тэнгэрийн тэтгэсэн хаан тусгайлан хүн томилж торгууд, дөрвөд зэрэг ойрадуудын суусан газарт илгээж сэмээр тэдний байдлыг сурвалжлуулсанд торгуудын ван Шээрэн, дөрвөдийн хан Магсаржав болон бусад ойрадын ноёд

⁴⁷ Васильев А.П. Забайкальские казаки. Т.2. Хабаровск. 2007, с.224-225

⁴⁸ М-1, Д-1, хн-481, х.13

Чин улсад үнэнч байгаагаа илэрхийлжээ⁴⁹. Энэ мэдээг сонссон Тэнгэрийн тэтгэсэн хаан Самайрин хэмээх Габун ламыг цуурхал тараасан хэргээр цаазаар авсан бөгөөд Оросын сенатаас худалдаа нээх ба хоёр улсын хооронд тогтоосон гэрээний зүйл заалтыг хэлэлцэн батлах тухай бичиг хүрч ирсэн тул 1791 оны 11 сард Хүрээнд хоригдон байсан тэргүүн ялт Жамц нарын урианхайг муу агаартай өмнөд мужуудад цөлөх зарлиг буулгав⁵⁰. Оросын сенатаас нэгэнт бичиг ирсэн учир мэйрэн занги Пүфү-г Сүн Юнтай хамт Хиагтад очин оросуудтай хэлэлцэж энэ хэргийг шийтгэж дуусгахаар явуулжээ.

“omšon biyai orin ninggun de isinjiha abkai wehiyehe i susai ningguici aniya omšon biyai juwan jakūn de hese wasimbuhangge. sungyun kuren de aniya goidaha, ne kiyagtu i hūda be neibuhe be dahame, pufu be kuren de unggifi, sungyun i sasa hūda neire baitai muru be icihiyame jabdufi, tubai baitai muru be urehe manggi, jai sungyun be amasi maribukini sehe.”⁵¹

“[1791 оны] арван нэгэн сарын хорин зургаанд хүрч ирсэн Тэнгэрийн тэтгэсний тавин зургадугаар оны арван нэгэн сарын арван найманд зарлиг буулгасан нь, Сүн Юн Хүрээнд он удав. Эдүгээ Хиагтад худалдааг нээлгэхийг даган, Пүфүг Хүрээнд илгээж, Сүн Юнгийн хамт худалдаа нээх хэргийг байдлыг шийтгэн завдаж тэндэх хэргийг барсан хойно сая Сүн Юн хойш буцтугай хэмээв.

Сүн Юнд урдын зэрэг дэвийг нь хэвээр олгуулж, Хүрээ сайдын газраас Эрхүүд бичиг явуулж Эрхүүгийн губернаторыг хаврын тэргүүн сарын эхэнд Хиагтад ирж хэлэлцэн энэ хэргийг дуусгахыг урьжээ. Хэлэлцээрийн явцад Хиагтын гэрээнд оруулсан гол өөрчлөлт нь хилийн газар гэмт хэрэг үйлдсэн этгээдийг шийтгэхдээ хоёр улс тус тусынхаа хууль цаазын дагуу шийтгэх бөгөөд ингэхдээ заавал нөгөө талын хяналтыг шаардахгүй гэсэн зүйл байжээ.

“Хоёр этгээдийн захын мунхаг бага улс хааяа нэгэнтээ зэр зэвсэгтэй явж хүн алсан илэрхий хулгай худлын их хэрэг буй болсон хойно даруй хуучин хуулийг дагаж тухайд ойрыг үзэж мөр түшаагаад энэ тогтоосон хугацааны ёсоор байцаан баригдсан хойно захад авч ирсэн хэрэг шийтгэгч түгшмэдийг

⁴⁹ М-1, Д-3, хн-59, х.1

⁵⁰ М-1, Д-1, хн-481, л.181; Оросууд нэгэнт Улалзай нарыг цаазаар авч шийтгээгүй учраас Жамц нарыг цөлж шийтгэхээр болжээ.

⁵¹ М-1, Д-1, хн-481, л.194

бүгдээр нийлж ам уулзуулан шүүж тодорхойлсон цагт Дундад улсын хүнийг дотоод газрын ёсоор шийтгэж Орос түшмэдэд үзүүлэх хэрэггүй. Оросын хүнийг орос цаазын ёсоор зоригоор шийтгэж Дундад улсын түшмэд мөн үзэхгүй өөрийн захын дотор цаазаар шийтгэсэн явдлыг хоёр этгээдийн түшмэд харилцан бичиг солилцоод хэрэг гарсан өөр өөрийн газрын харьяат улсад ухуулаад бат цээрлэл үзүүдмөй."

Оросууд Чингийн сайд нарт бэлэг сэлт хэмээн өгөх эд зүйлс болон Оросын төв засгаас олгосон мөнгөнөөс 5000 рублийг зарцуулсан аж⁵². Үүнээс бусад зүйлийг өөрчлөлгүй үлдээсэн бөгөөд бага мэт боловч үүн шиг буултыг Чингийн талаас хийлгэж чадсан нь улам бүр дэвжин хөгжиж буй Оросын дипломатын анхны томоохон амжилт гэж хэлж болохоор юм. Тэнгэрийн тэтгэсний тавин долдугаар оны цагаан сарын хорин долоонд [оросын хуучин тооллоор 1792.02.08] Оросын Хиагт хотноо Эрхүүгийн губернатор Людвиг Нагель, Хүрээний сайд Сүн Юн нар Буурын гэрээний 1768 оны нэмэлт заалтад өөрчлөлт оруулснаа батлан орос, монгол, манж гурван үсгийн бичиг солилцон тамга дарж баталгаажуулаад Хүрээний газар хоригдон байсан оросын харьяат Боргил, Содов хэмээх 2 буриад, Михайл хэмээх 1 орос хүнийг буцаан өгч, Улаалзайн хэмээгдсэн энэ нэг хэргийг шийдвэрлэн дуусгасан байна. 1792 оны 4 сард Хиагтын газар хятад худалдаачид буцан ирж 5 сараас нь эхлэн Хиагтын худалдаа хуучин ёсоор явагдах болов. Эрхүүгийн генерал-губернатор Пиль 1792 оны 10 сард Сенатад Хиагтын худалдаа нээгдсэнээс хойш хураасан гаалийн татвар нийт 182,383 рубль болсныг мэдүүлжээ⁵³.

Дүгнэлт

1783 онд Оросын харьяат буриад нар Чингийн харьяат урианхайчуудтай нийлэн Чингийн хилийн дотор хятад худалдаачныг тоносон нэгэн хэргээс үүдэн Орос-Чингийн харилцаан дахь олон хурц асуудлууд хөндөгдөн гинжин урвалаар гарч ирсэн нь XVIII зууны сүүл хагасын хүчирхэгжлийнхээ дээд үедээ ороод нэгэнт буурах замдаа орж явсан манж Чин гүрэн болон улам бүр хүчээ аван өсч яваа Орос хоёрын хоорондын харилцаанд Чин гүрэн давамгайлж өөрийн хүсэл зоригоо Орост тулгадаг байсан явдал өнгөрөх тийшээ хандсаныг харуулжээ. Оросын хүчирхэгжиж буйгаас ихэд болгоомжилж байсан Тэнгэрийн тэтгэсэн хаан энэ хэргийг ашиглан Орост Чин гүрний байр суурь ганхаагүй хүчирхэг хэвээр байгааг харуулахыг тууштай

⁵² Архивъ государственного совета. Томъ первый. Советъ въ царствование императрицы Екатерины II. (1768-1796). Санктъ-Петербургъ, 1869. с.655

⁵³ Архивъ государственного совета. Томъ первый. Советъ въ царствование императрицы Екатерины II. (1768-1796). Санктъ-Петербургъ, 1869. с.658

зорьсон мэт харагдаж байна. 1784-1792 оны хооронд өрнөсөн үйл явдлын дундаас бид Орос-Чингийн харилцаан дахь дараах хэдэн зүйлийг тодруулж болох юм. Чингийн талаас ялангуяа Тэнгэрийн тэтгэсэн хааныг хил орчмын монголчууд оросын харьяатуудтай чөлөөтэй харилцаж, харуулын албыг “хөсөрдүүлж” явдгийг мэдээд ихэд цочирдож, хил харуулын албыг чангаруулж, монголчуудын оростой харилцах явдлыг болиулахаар чармайжээ. Хиагтын худалдааг зогсоож, харуулын дотуур бас дахин цагдаа өрхүүдийг суулгасан нь хэдий хятад худалдаачдыг сэргийлэх зорилготой гэвч бас давхар монголчуудын оростой харилцахыг хянах гэсэн оролдлого байсан бололтой. Оросууд Чингийн талыг шалгаж өдөөн хатгаж байна гэж үзсэн учраас Тэнгэрийн тэтгэсэн хаан энэ хэрэгт ихээхэн хатуу байр суурь баримталж буриад нар Чинд дагах вий гэж болгоомжилсны үүднээс оросууд ийм хачин байр суурь баримталж байна гэж хардаж байв. Дээр нь Оросоос дагаар ирсэн халимаг торгууд нарыг цэргийн хүчээр буцаан авах гэж байна гэсэн цуу нэрмээс болсон боловч, 7 жил худалдааг хаахад оросууд ерөнхийдөө Чинтэй сөргөлдөх санаагүй байна гэж мэдсэн Тэнгэрийн тэтгэсэн хаан эцсийн дүндээ оросуудад бага зэрэг буулт хийж Хиагтын худалдааг сэргээсэн байна. Хиагтын худалдаа бол оросуудыг дарамталж болдог Чингийн талд байсан хамгийн том хөзөр байсан юм. Энэ удаагийн худалдааг зогсоосон нь энэ хөзрийг эцсийн удаа ашигласан явдал байжээ. Оросуудын хувьд Алс дорнодод байр суурь нөлөөгөө тэлэх өргөн цараатай цогц бодлогоо боловсруулж амжаагүй байсан цаг үе тул Чин улстай харилцааг муутгаж, худалдааг зогсоох нь эдийн засгийн улс төрийн хувьд ашиггүй байв. Гэвч өөрсдийн байр суурийг хамгаалан зогссоор байж Чингийн талаас анх удаагаа буулт хийлгүүлж авсан нь оросуудын хувьд том амжилт болоод зогссонгүй Монгол болон Амар мөрний хавийг нэгтгэх алсын бодлогоо хэрэгжүүлэхэд нь энэ удаагийн хэрэг эхний алхам болж өгчээ.


Abstract: The Kyakhta trade between Russia and Qing was very important to the Russian state, as one of the main source of the state income. The Qing knew it and on occasions used to stop the trade to pressure the Russian Tsar. In 1784 the some Russian buryat subjects and the uriyangqais of the Qing side together robbed the Chinese merchant in Khuvsgul region. The Russian way of punishment of the caught robbers irritated the Qing side and became a new reason to stop the trade for seven years. During these seven years, until the both side came to common understanding, many events occurred that showed the all problematic sides of the relations between two empires.

1792 онд Орос болон Чингийн хооронд тогтоосон олон улсын зөвшилцлийн бичиг. (монголоор)

Их Дайчин улсын захын хэргийг шийтгэгч үйлдэх явдлын яамны зүүн этгээдийн асхани амбан, шулуун цагааны манж хошууны мэйрэн занги Сүн Юн, Жиян Чин Мэнд явах халхын Хан уулын чуулганы дарга засгийн хошууны бэйс Сүндэвдорж, Хөвөөт хөхийн монгол хошууны мэйрэн занги бөгөөд сурвалжит сумны занги Пүфү, Орос улсын захын хэргийг шийтгэгч, Эрхүү хотны губернатор цэргийн генерал майор кавалер Людвиг Нагель бүгдээр нийлж эвээр найртай ёсоор тогтоож хэлэлцсэн нь, Их богд эзэн бүхий олон амьтныг нэгэн адил асран санаж, сенат яамнаас хичээнгүй эетэйгээр гуйсан ёсоор Хиагтын маймай нээтүгэй хэмээн өршөөлт зарлиг буугаар ирэв. Үүнээс урагш эрхгүй Их богд эзний зарлигаар сургасан ёсоор жич бас хуулиас зөрчихгүй, найрыг эвдэж явахгүй, чин үнэнээр итгэмжээ сахьмой хэмээх эл явдыг губернатор хичээнгүй эетэйгээр хүлээн авсны тулд Хиагтын худалдаа хийх маймай иргэчүүдийг дуудаж ирснийг үзэж найртайн ёсоор хуучин ёсоор худалдаа хийлгэмой хэмээн тогтоов. Хоёр этгээдийн маймай улсыг тус тусаар захиргаж, аливаа арилжсан юмыг харилцан болзсон өдрөөс өнгөрүүлэлгүй даруй дээр дуусгаж өр дутуулахгүй явдлыг губернатор хичээнгүй эетэйгээр дагаж оросын маймай улсыг тун тэмцэлдэх ов дэгдүүлэлгүй болгож дуртайяа хүсч батлав. Захын газраа байх сайн чадалтай подполковник майор зэрэг түшмэдийг заргач, засаг лугаа хэрэг шийтгүүлж, эдүгээх поручик коллежский регистратор мэт сайн түшмэдийг зайсангууд лугаа найр авч яван, хоёр этгээдийн маймай улсыг тус тусаар чандлан захиргаж үүрд хэрэг дэгдүүлэлгүй болгов. Энэ удаа Их богд эзэн ийнхүү гайхамшигт хишиг хүртээв хэмээн сүслэн баясч зах дахь бүхий эл буриад хариад зэрэг улсыг чандлан захиргаж дураар хулгай худлын зэрэг хэрэг дэгдүүлэлгүй болгов. Захын газраа хууль чанга болвоос доодох мунхаг бага улс айгаад дураар халдаж явахгүй үнэхээр хэрэгт үүрд тустай. Орос сенат яамнаас хичээнгүй эетэйгээр гуйсан явдлыг Их богд эзэн гэгээнээр айлдаад нэгэнт тэнгэрийн хишиг хүртээсний тулд, ер өөр хууль халахуйг хэрэгсэхгүй, хэвээр урьдын ёсоор шийтгэтүгэй. Хоёр этгээдийн захын мунхаг бага улс хааяа нэгэнтээ зэр зэвсэгтэй явж хүн алсан илэрхий хулгай худлын их хэрэг буй болсон хойно даруй хуучин хуулийг дагаж тухайд ойрыг үзэж мөр тушаагаад энэ тогтоосон хугацааны ёсоор байцаан баригдсан хойно захад авч ирсэн хэрэг шийтгэгч түшмэдийг бүгдээр нийлж ам уулзуулан шүүж тодорхойлсон цагт Дундад улсын хүнийг дотоод газрын ёсоор шийтгэж Орос түшмэдэд үзүүлэх хэрэггүй. Оросын хүнийг орос цаазын ёсоор зоригоор шийтгэж Дундад улсын түшмэд мөн үзэхгүй өөрийн захын дотор цаазаар шийтгэсэн явдлыг хоёр этгээдийн түшмэд харилцан бичиг

солилцоод хэрэг гарсан өөр өөрийн газрын харьяат улсад ухуулаад бат цээрлэл үзүүлмой. Булааж авсан юм торгож төлүүлэх эл явдлыг бүрнээ уг тогтсон хуучин хуулийн аравдугаар зүйлийг хичээнгүйлэн дагаж хэрхэвч бээр осолдолгүй шийтгэж ер үг мэлзэхгүй. Их богд эзний зарлигийг дагаж эдүгээх хэлэлцсэн маймай нээх эл хэргүүд нэгэн адил бичиж харилцан солиод Хүрээнд хоригдсон Боргил Содов Михайл гурван хүнийг хойш олгуулсан явдлыг Их журганаас уг тушаасан ёсоор Хүрээний амбас Гадаад Монголын төрийг засах явдлын яамнаа мэдүүлэн Эрхүүгийн губернатор сенат яаманд мэдүүлээд бат тэмдэг болгохын тул Дундад улсын амбас манж монгол хоёр зүйлийн үсгээр нэгэн адил хавсран бичиж тамга дараад Орос улсын губернаторт өгч хадгалуулвай. Орос губернатор манж монгол орос гурван зүйлийн үсгээр нэгэн адил хавсран бичиж тамга дараад Дундад улсын амбаст өгч хадгалуулвай. Тэнгэрийн тэтгэсний тавин долдугаар он хаврын тэргүүн сарын хорин долооноо.⁵⁴ [1792.02.21]

Хавсралт.№2 Кнут буюу ташуураар шийтгэж буй байдал.



SUPPLICE DU GRAND KNOUT.

⁵⁴ Энэ зөвшилцлийн бичгийг оросоор Международный акт буюу Олон улсын акт хэмээн нэрийдсэн байдаг бөгөөд орос эх нь "Сборникъ договоровъ Россіи с Китаемъ. 1689-1881" Санкт-Петербург. 1889, эмхтгэлийн 93-95-р талд буй.